

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: БУА-2021/01/СТА-ТЕЗ

БУЛГАН АЙМАГ 2021 ОН

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 9907-9641 Цахим хаяг: tserenlhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

<p>Тайланг бэлтгэсэн: Тэргүүлэх аудитор Д.Анхбаяр</p> <p>Аудитын менежер Ж.Энхцоодол</p> <p>Аудитор Г.Цэрэнлхам</p> <p>Хаяг: Булган аймаг ЗДТГ байр. 4 давхар 410 тоот</p> <p>Цахим хуудас: Tailan.audit.mn</p> <p>Аудитын тайлантай холбоотой асууж тодруулах зүйл байвал 7034-2495, 7034-2580 дугаарын утсаар харилцана уу.</p>	<p>Агуулга Товчилсон үгийн жагсаалт2 Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....5</p> <p>Үндсэн мэдээлэл <i>Төсвийн өөрчлөлтөөр санхүүгийн дэмжлэгийг 15.3 хувь, ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 13.6 хувиар, ТЗШ-ийг 1.2 хувиар тус тус бууруулан баталжээ.</i></p> <p>1.1 Төсвийн зорилт.....6 1.2 Төсвийн бүтэц.....6 1.3 Төсвийн онцлог.....7-8 1.4 Төсвийн төлөвлөлт.....8-10</p> <p>Бүлэг 1. 1.1 Орон нутгийн төсвийн орлого 5.2 хувиар тасарч, өмнөх оноос 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 1.1.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл..... 10-11 1.1.2 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл..... 11 1.1.3 Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл..... 12</p> <p>Бүлэг 2. 2.1 Төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийг үрэлгэн, зориулалт бус зарцуулсан зэрэг алдаа, зөрчил өмнөх оноос 63.8 хувиар өсчээ. 2.1.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл..... 13 2.1.2 Аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл..... 15 2.1.3 Сумдын төсвийн зарлагын гүйцэтгэл..... 15</p> <p>Бүлэг 3. 3.1 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 91.6 хувьтай гарч, өмнөх оноос 4,716.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. 3.1.1 ОНТ-ийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл..... 15-16 3.1.2 Замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл.... 16 3.1.3 Аймгийн ОНХС-гийн санхүүжилтийн гүйцэтгэл.... 16 3.1.4 Улсын төсвийн ХО-ын гүйцэтгэл..16 3.1.5 Сумын ОНХС-гийн санхүүжилтийн гүйцэтгэл..... 16</p> <p>Бүлэг 4. Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаа зөрчил арилаагүй хэвээр байна..... 16-17</p> <p>Дүгнэлт..... 17</p> <p>Зөвлөмж..... 17</p>
--	---

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УИХ	Улсын Их Хурал
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ТҮА	Тохижилт үйлчилгээний анги
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЭӨЦС	Эрдмийн өргөө цогцолбор сургууль

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн төсвийн орлогод оруулсан өөрчлөлт	7
Хүснэгт 2	Сумдын батлагдсан төсвийн орлогод оруулсан өөрчлөлт	7-8
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт	9
Хүснэгт 4	Өмнөх онтой төсвийн орлогыг харьцуулбал	10
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	11
Хүснэгт 6	Зардлын ангилал	12-13

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</p>	<p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</p> <p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Төсвийн тухай хуулийн 8.9.2¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн Булган аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийв.</p>
<p>Аудитын зорилт</p>	<p>2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалтаар аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийг мэдээллээр хангахад энэхүү аудитын чиглэгдлээ.</p>
<p>Аудитын хамарсан хүрээ</p>	<p>Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.1-54.5.5-т заасны дагуу аймгийн 2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Аймгийн нэгдсэн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний танилцуулга /<i>нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр</i>/ ➢ Татварын зарлагын судалгаа /<i>иргэдэд олгосон ХХОАТ-ын хөнгөлөлт</i>/ ➢ 2020 оны худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл. ➢ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл. ➢ Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүн /<i>Хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, түүний үр дүн нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан шалтгаан</i>/
<p>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</p>	<p>Аудитыг гүйцэтгэхдээ АОУС, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан санхүүгийн гарын авлага, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон санхүү төрийн сангийн хэлтэс, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав</p>
<p>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</p>	<p>Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Цэрэнлхам нар 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.</p> <p>Аудит хийхэд учирсан хүндрэл бэрхшээл:</p> <p>ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийхэд аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн тус бүрээр гаргаж ирүүлээгүй, зөрүүтэй тоон мэдээллийг дахин тулган баталгаажуулахад цаг хугацаа их зарцууллаа.</p>

¹ “Орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлддүгнэлт өгөх”

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

1.1 Төсвийн өөрчлөлтөөр санхүүгийн дэмжлэгийг 15.3 хувь, ОНХС-гийн орлогын шилжүүлгийг 13.6 хувиар, ТЗШ-ийг 1.2 хувиар тус тус бууруулан баталжээ.

1.1 Төсвийн зорилт

Орон нутгийн төсвийг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр², аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны зорилтыг хэрэгжүүлэх,
- Татварын бааз суурийг өртгөтгөх, татвар ногдуулах, хураах үйл ажиллагааг шинэ шатанд хүргэн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, Төсвийн үр ашиггүй зардлыг танаж, хэмнэлтийн горимд шилжүүлэх замаар төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх,
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх,
- Бэлчээрийн зохистой ашиглах, эзэмшүүлэх, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар даацыг нэмэгдүүлэх, Зам тээвэр, барилгын салбарыг хөгжүүлж, орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, Ойн нөөцийн менежментийг сайжруулж, зохистой ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх,
- Амжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийг нийт өрхөд эзлэх хувийг нэмэгдүүлэх, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг хангах, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах,
- Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, эрсдлийг бууруулах, Төрийн цэргийн бодлогын хүрээнд батлан хамгаалах бодлого, зорилтыг орон нутагт хэрэгжүүлэх, эцэг-эх, цэрэг-дайчид, төр захиргааны байгууллагуудын холбоог нэмэгдүүлж, ирээдүй болсон хүүхэд залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх,

1.2 Төсвийн бүтэц:

Аймгийн нэгдсэн төсөв нь аймгийн шууд харьяа байгууллагууд болон сумын төсөв гэсэн 2 хэсгээс бүрддэг. 2020 оны орон нутгийн төсөв нь дараах үндсэн бүтэцтэй байна. Үүнд:

1. Аймгийн шууд болон сумдуудын төсөв
2. Аймаг, сумын ОНХС-д олгох шилжүүлэг
3. Сумдуудад олгох санхүүгийн дэмжлэг
4. Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлэг

1.3 Төсвийн онцлог:

Төсвийн урсгал зардлыг Монгол улсын 2020 оны төсвийн тухай хууль, холбогдох бусар хууль, эрх зүйн хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутагт үүссэн тулгамдсан асуудал, зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, өр төлбөр үүсгэх байх нөхцлийг хангах, төсвийн үргүй зардлыг багасгах, хэмнэлтийн горимыг сахих, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлийг баримталжээ.

Төсвийн орлого 71,671,857.1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 67,948,370.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 3,723,486.2 мянган төгрөг буюу 5.2 хувиар тасарсан, Төсвийн зарлага 71,671,857.1 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 64,528,242.1 мянган төгрөгийг зарцуулж, 7,143,615.0 мянган төгрөг буюу 9.9 хувиар дутуу зарцуулсан байна.

² Аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” мөрийн хөтөлбөр

Өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад төсвийн орлого 8,034,768.6 мянган төгрөг буюу 13.4 хувиар, зарлага 3,858,098.3 мянган төгрөг буюу 5.9 хувиар өссөн байна.

Сангийн яамнаас аймгийн төсвийн суурь орлогыг 23,088,819.3 мянган төгрөг, суурь зарлагыг 27,047,934.9 мянган төгрөгөөр хянажээ. Өмнөх онтой харьцуулж үзэхэд суурь орлогыг 1,372,104.3 мянган төгрөгөөр, суурь зарлагыг 4,040,836.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлжээ.

УИХ-аас аймгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 3,958,858.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 3,292,547.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

1.4 Төсвийн төлөвлөлт:

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2³ дахь заалтыг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны XV/05 дугаар тогтоолоор аймгийн 2020 оны төсөвт 1 удаа өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

Хүснэгт 1: Аймгийн төсвийн орлогод оруулсан өөрчлөлт: мянган төгрөг

ОРЛОГЫН ТӨРӨЛ	2019.12.05 XIV/04	2020.09.05 XIV/04	Өөрчлөлт орсон
АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО БҮГД	65,084,420.8	63,575,316.0	(1,509,104.8)
Оны эхний үлдэгдлээс	704,563.5	821,654.0	117,090.5
УРСГАЛ ОРЛОГО	19,822,544.0	19,829,331.3	6,787.3
ТАТВАРЫН ОРЛОГО	19,416,844.0	19,226,844.0	(190,000.0)
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	405,700.0	602,487.3	196,787.3
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	21,000.0	43,000.0	22,000.0
Тусламжийн орлого	44,536,313.3	42,881,330.7	(1,654,982.6)
Санхүүгийн дэмжлэг	4,677,725.1	3,958,848.5	(718,876.6)
Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	3,810,215.3	3,292,547.0	(517,668.3)
Тусгай зориулалтын шилжүүлэг	35,627,875.4	35,209,437.7	(418,437.7)
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	420,497.5	420,497.5	-

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Аймгийн 2020 оны XIV/04 дугаар тогтоолоор төсвийн орлого болон зардлын санхүүжилтийн эх үүсвэрт дараах нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүнд:

- Зам ашигласны төлбөр 60,000.0 мянга, хүү торгуулийн орлого 16,900.0 мянга, нэр заагдаагүй бусад орлого 159,600.0 мянга, хөрөнгө борлуулсны орлого 22,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн төсвийн 2019 оны орлого давалт болон зардлын хэмнэлтийн 117,090.5 мянган төгрөгийг урсгал болон хөрөнгийн зардалд нэмж зарцуулахаар,
- МУ-ын 2020 оны төсвийн тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр өөрчлөлт оруулан санхүүгийн дэмжлэг 718,876.6 мянга, ОНХНС-гийн орлогын шилжүүлэг 517,668.3 мянга, тусгай зориулалтын шилжүүлэг 418,437.7 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Хүснэгт 2: Аймгийн төсвийн зарлагад оруулсан өөрчлөлт: мянган төгрөг

Д/д	Төсвийн захирагч	2019.12.05 XIV/04	2020.09.05 XIV/04	Өөрчлөлт орсон
Төсвийн нийт зардал. Үүнээс:		65,084,420.8	63,575,316.0	(1,509,104.8)
	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	613,428.4	542,261.7	(71,166.7)
	Урсгал зардал	613,428.4	542,261.7	(71,166.7)
	Хөрөнгийн зардал	-	-	-
	ИТХ-ын нарийн бичгийн дарга. Үүнээс:	613,428.4	542,261.7	(71,166.7)

³ Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, нэгдсэн төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний гурван хувиар нэмэгдэх.

3.1	3.1.1	Үндсэн үйл ажиллагаа	375,678.4	303,112.8	(72,565.6)
		Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	139,500.0	140,898.9	1,398.9
		ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	8,250.0	8,250.0	-
		Гэмт хэргээс урьдчилэн сэргийлэх зохицуулах зөвлөлийн зардал	90,000.0	90,000.0	-
3.2	Засаг дарга		64,470,992.4	63,033,054.3	(1,437,938.1)
	Урсгал зардал		61,528,095.8	55,308,392.2	(6,219,703.6)
	Хөрөнгийн зардал		2,942,896.6	7,724,662.1	4,781,765.5
3.3	Үүнээс: Сумдад олгох санхүүгийн дэмжлэг		5,634,939.1	5,553,123.7	(81,815.4)
3.4	Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг		1,280,907.8	1,141,710.2	(139,197.6)
3.5	Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ		34,870,699.5	34,870,699.5	-

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Төсвийн зардлуудад дараах нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүнд:

- Аймгийн байгаль орчныг хамгаалах, байгалийн баялаг нөхөн сэргээх чиглэлээр 2, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1 арга хэмжээг шинээр нэмж, 47 төсөл арга хэмжээг 681,034.5 мянган төгрөгөөр бууруулан зарцуулахаар,
- МУ-ын 2020 оны төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр санхүүгийн дэмжлэг, ОНХНС-ийн орлогын шилжүүлгийг бууруулсантай холбоотойгоор зарим байгууллагуудын үйл ажиллагааны зардлыг бууруулсан.

Сумдын төсвийн орлого, зарлагыг сумын ИТХ-ын тогтоолоор төсөвт өөрчлөлт оруулан 1 удаа тодотгож, зарлагыг 54,611,308.1 мянган төгрөгөөр баталсан нь анх баталсан төсвөөс орлого, зарлагыг 858,841.9 мянган төгрөгөөр бууруулжээ. Энэ нь санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлэгийг буурсантай холбоотой байна.

Хүснэгт 3: Сумдын батлагдсан төсвийн орлогод орсон өөрчлөлт

/мянган төгрөг/

д/д	Сумдын нэр	Сумдын урсгал орлого	ОНХС	Санхүүгийн дэмжлэг	Орон нутгийн төсвөөс	ТЗШ-ийн байгууллагууд	Нийт төсвийн өөрчлөлтийн дүн
1	Баян-Агт	-	(4,103.0)	(11,924.5)	53,502.4	3,520.2	40,995.1
2	Бугат	-	(60,449.5)	(8,247.8)	29,050.0	(18,371.5)	(58,018.8)
3	Бүрэгхангай	-	(23,992.2)	(10,659.1)	(3,892.0)	(71,660.4)	(110,203.7)
4	Гурванбулаг	-	7,574.5	(12,062.6)	(4,027.9)	(73,831.0)	(82,347.0)
5	Дашинчилэн	-	(8,890.2)	(10,567.3)	10,231.3	(107,187.4)	(116,413.6)
6	Могод	1,800.0	84,504.6	(11,556.2)	(68,567.1)	(34,228.3)	(28,047.0)
7	Орхон	5,600.0	8,791.9	4,621.7	14,577.7	(37,996.8)	(4,405.5)
8	Сайхан	(2,740.0)	(8,524.7)	(11,441.9)	46,304.7	(136,260.3)	(112,662.2)
9	Сэлэнгэ	296,499.9	(13,158.9)	(12,572.3)	294.4	50,501.0	321,564.1
10	Тэшиг	60,358.0	38,572.2	(7,383.1)	10,440.3	23,348.0	125,335.4
11	Хангал	(30,160.0)	46,673.9	20,982.0	15,678.2	4,586.7	57,760.8
12	Хишиг-Өндөр	5,000.0	23,026.6	(9,377.0)	4,488.6	(112,313.2)	(89,175.0)
13	Хутаг-Өндөр	317,943.9	(6,632.3)	(13,293.9)	(21,173.0)	(39,804.5)	237,040.2
14	Булган	-	(5,289.3)	43,286.0	(18,420.2)	(977,718.8)	(958,142.3)
15	Баяннуур	1,258.6	141,056.2	(9,943.7)	20,122.6	(112,875.3)	39,618.4
16	Рашаант	-	(2,896.3)	(13,028.9)	41,519.8	(102,127.1)	(76,532.5)
17	Хялганат	9,000.0	3,485.4	(8,646.8)	(22,877.3)	(26,169.6)	(45,208.3)
	ДҮН	664,560.4	219,748.9	(81,815.4)	107,252.5	(1,768,588.3)	(858,841.9)

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

1.1 Орон нутгийн төсвийн орлого 5.2 хувиар тасарч, өмнөх оноос 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.1.1 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл:

2020 оны төсвийн орлогыг бүрдүүлэхдээ төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татварын ногдуулалт, төлөлтөд тавих хяналтыг сайжруулах, аймгийн ЗД-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтыг хангах ажлын хүрээнд төсвөөс санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд анхаарч ажиллажээ.

Хүснэгт 4: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	71,671,857.1	67,948,370.9	3,723,486.2	94.8
Татварын орлого	21,824,435.1	23,314,634.7	(1,490,199.6)	106.8
Орлогын албан татвар	4,662,387.0	6,150,174.7	(1,487,787.7)	131.9
Хувь хүний орлогын албан татвар	5,262,387.0	6,623,113.2	(1,360,726.2)	125.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(600,000.0)	(472,938.5)	(127,061.2)	78.8
Хөрөнгийн албан татвар	815,941.0	1,103,495.2	(287,554.2)	135.2
Бусад татвар, төлбөр, хураамж	16,346,107.1	16,060,964.8	285,142.3	98.2
Бусад нийтлэг төлбөр, хураамж	898,988.2	1,101,568.4	(202,580.2)	122.5
Газрын төлбөр	557,962.3	1,168,559.4	(610,597.1)	209.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	14,829,156.6	13,790,837.0	1,038,319.6	93.0
Бусад татвар	60,000.0	-	60,000.0	-
Татварын бус орлого	46,828,470.8	43,742,644.5	3,085,866.3	92.8
Нийтлэг татварын бус орлого	3,996,937.3	3,948,296.8	(48,640.5)	98.8
Хөрөнгийн орлого	43,000.0	43,656.0	(656.0)	101.5
Тусламжийн орлого	420,497.5	359,551.9	60,945.6	85.5
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	42,460,404.7	39,388,946.0	3,071,887.3	92.8
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	35,209,437.7	32,540,649.6	2,668,788.1	92.4
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	3,292,547.1	2,889,447.9	403,099.2	87.8
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	3,958,848.5	3,958,848.5	-	100.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,925,296.6	891,091.8	2,034,204.8	30.5

Эх сурвалж: Булган аймгийн ТЭЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Төсвийн орлогын гүйцэтгэлийг бүтцээр нь авч үзвэл татварын орлого 34.3 хувь, татварын бус орлого 7.1 хувь, хөрөнгийн орлого 0.1 хувь, тусламж, санхүүжилтийн орлого 58.5 хувийг бүрдүүлжээ.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө 1,598,249.1 мянган төгрөг буюу 106.8 хувиар давсан байна. Үүнд: хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, АТБӨЯХАТатвар, улсын тэмдэгтийн хураамж, хог хаягдал үйлчилгээний хураамж, хүүгийн орлого, торгуулийн орлого, ТБӨО, хөрөнгийн орлого, бусад орлого, газрын төлбөр 656.0- 1,360,726.2 мянган төгрөг буюу 7.2-125.8 хувиар биелүүлж, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр, түрээсийн орлого, бусад татварын орлого 370.0–1,100,710.2 мянган төгрөг буюу 4.9-100 хувиар тасарчээ.

Өмнөх оны гүйцэтгэлээс 11.6 хувь буюу 2,946,894.7 мянган төгрөгөөр орлогыг илүү бүрдүүлжээ.

Хүснэгт 5: Өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулбал:

мянган төгрөг

Төсвийн орлогын ангилал зүйл	2019 оны гүйцэтгэл		2020 оны гүйцэтгэл		Зөрүү	
	Дүн	Хувийн жин	Дүн	Хувийн жин	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	59,913,602.3	100.0	67,948,371.0	100.0	8,034,768.7	13.4
УРСГАЛ ОРЛОГО	25,216,311.1	42.1	28,199,873.0	41.5	2,983,561.9	11.8
ТАТВАРЫН ОРЛОГО	21,977,071.3	87.2	23,314,634.7	82.7	1,337,563.4	6.1
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,239,239.8	12.8	4,885,238.3	17.3	1,645,998.5	50.8
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	34,697,291.2	57.9	39,748,498.0	58.5	5,051,206.8	14.6

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Нийт орлогын дүнд урсгал орлогын эзлэх хувийн жин өмнөх оноос 0.6 пунктээр буурахад татварын орлого 4.5 пунктээр буурсан нь нөлөөлжээ.

1.1.2 Аймгийн төсвийн орлогын гүйцэтгэл:

Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 19,286,844.0 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 19,854,509.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 567,665.9 мянган төгрөг буюу 102.1 хувиар давж биелэжээ. Тухайлбал: хувь хүний орлогын албан татвар, АТБӨЯХАТатвар, үл хөдлөх албан татвар, газрын төлбөр 295,524.7-1,032,203.1 мянган төгрөгөөр давж биелсэн, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 1,108,452.4 мянган төгрөгөөр биелээгүй байна.

Аймгийн төсвийн орлого 295,524.7-1,032,203.1 мянган төгрөгөөр давж биелэсэн нь дараах нөхцөл байдлаас шалтгаалжээ. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тушаалаар төрийн албан хаагчдын цалинг 8 хувиар нэмэгдсэн, өмнөх оны татварын үлдэгдэл, УИХ-ын болон Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуультай холбоотой цалин, урамшуулал олгосон,
- Аймгийн ИТХ-аас салбар компаниудын хувьд үл хөдлөх хөрөнгийн албан татварын хувь хэмжээг өөрчлөн нэг хувь болгон нэмэгдсэн,
- Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолоор сумдын ИТХ-аас газрын төлбөрийн суурь үнэлгээ нэмэгдсэн, Мөн газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс 130,755.9 мянган төгрөгөөр давж биелэсэн,
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар давж биелэсэн нь АТҮТ-ын Булган салбарт бүртгэлтэй АТБӨЯХ-ийн тоо 6460⁴ -аар илүү байгаагаас, өмнөх оны тээврийн хэрэгслийн албан татварын дутуу үлдэгдэл төвлөрүүлэгдсэн зэрэг байна.

Харин үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 1,094,654.9 мянган төгрөгөөр тасарсан нь Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох журам”-аар гэрээнээс илүү ашигласан усны хэмжээгээр шатлан өсгөж, төлбөр ногдуулдаг болсоноос Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ тухайн жилийн ус ашиглах гэрээнд “жилд ашиглахаар төлөвлөсөн усны 15 хүртлэх хувийг хэмнэх зорилт тавина” гэж зааснаас усны хэмнэлтийн горимд шилжин саарал ус ашиглаж байгаагаас шалтгаалжээ.

Тусламжийн орлого 9,051,610.1 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 9,104,045.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 52,435.0 мянган төгрөгийн орлогыг илүү бүрдүүлэхэд нийтлэг татварын бус орлого 354,473.9 мянган төгрөг буюу 64.7 хувь, давж, ОНХНС-гаас шилжүүлсэн орлого 266,836.1 мянган төгрөг буюу 12.9 хувиар дутуу санхүүжүүлсэн, ТШЗ-ийн байгууллагын санхүүжилт 34,818.8 мянган төгрөг буюу 1.4 хувиар төсөвт татан төвлөрүүлсэн зэрэг нь нөлөөлжээ.

⁴ АТҮТ-ийн Булган салбараас 2020 оны 12 дугаар сарын 03-нд ирүүлсэн албан тоот.

ТШЗ-ийн байгууллагын санхүүжилт өмнөх оноос 3,028,706.9 мянган төгрөгөөр, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 2,648,465.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, улсын төсвөөс хуваарилсан ОНХС-гийн шилжүүлгийн орлогын 625,965.2 мянган төгрөгөөр буурчээ.

1.1.3 Сумдын төсвийн орлогын гүйцэтгэл:

Сумдын төсвийн орлого 3,135,453.3 мянган төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр 4,177,720.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 1,042,267.4 мянган төгрөгөөр буюу 33.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Сумдын төсвийн орлого давсан шалтгаан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.14⁵ зааснаар газрын төлбөрийн орлогын 40 хувь сумын төсвийн орлогод төвлөрүүлэхээр болсон байна. Гэвч сумдууд 2020 оны төсөвт өөрчлөлт оруулахдаа газрын төлбөрийн орлогыг төлөвлөгөөгүй байна.

Сумдын төсвийн орлого нь аймгийн төсвийн орлогын 17.5 хувийг эзэлж байна. Өмнөх оны гүйцэтгэлээс 602,846.2 мянган төгрөг буюу 20.3 хувиар илүү орлого бүрдүүлсэн байна.

Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийг нэр төрлөөр нь авч үзвэл дараах орлогууд тасарсан байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого 4,428.5 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар тасарсан. Тухайлбал: Баян-Агт сум 1,945.5 мянга, Дашинчилэн сум 2,256.6 мянга, Хутаг-Өндөр сум 171.9 мянган төгрөг.
- Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого 76,336.6 мянган төгрөг буюу 15.5 хувиар тасарсан. Тухайлбал: Могод 6,201.1 мянган төгрөг.
- Бууны албан татвар 8,905.8 мянган төгрөг буюу 17.1 хувиар тасарсан. Тухайлбал: Баян-Агт сум 2,778.5 мянга, Баяннуур сум 784.0 мянга, Булган сум 2,226.8 мянга, Бүрэгхангай сум 1,044.0 мянга, Дашинчилэн сум 240.0 мянга, Могод сум 3,298.0 мянга, Орхон сум 383.0 мянга, Сайхан сум 1,275.0 мянга, Хангал сум 31.6 мянга, Хутаг-Өндөр сум 123.0 мянган төгрөг.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого 12,700.9 мянган төгрөг буюу 40.6 хувиар тасарсан. Тухайлбал: Баян-Агт сум 10.4 мянга, Булган сум 560.0 мянга, Дашинчилэн сум 63.1 мянга, Могод сум 159.0 мянга, Орхон сум 3,137.3 мянга, Хангал сум 1,878.4 мянга, Хишиг-Өндөр сум 348.3 мянган төгрөг.
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж нийт дүнгээрээ 10,954.3 мянган төгрөг давсан боловч зарим сумдууд орлогыг төлөвлөгөөг тасарсан байна. Тухайлбал: Бугат сум 686.0 мянга, Дашинчилэн сум 736.8 мянга, Рашаант сум 847.1 мянга, Сайхан 735.8 мянга, Хангал сум 1,567.1 мянга, Хишиг-Өндөр сум 1,927.6 мянган төгрөг байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийг үрэлгэн, зориулалт бус зарцуулсан зэрэг алдаа, зөрчил өмнөх оноос 63.8 хувиар өсчээ.

2.1.1 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн нийт зарлага 71,671,857.1 мянган төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 64,528,242.1 мянган төгрөг зарцуулж, 90.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оноос 3,858,098.3 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Төсвийн зардлын бүтцээр нь эдийн засгийн ангиллаар авч үзвэл урсгал зардалд 98.0 хувийг зарцуулсан ба үүнээс бараа үйлчлэгээний зардалд 89.6 хувь, татаас урсгал шилжүүлэгт 6.5 хувь, хөрөнгийн зардалд 2.0 хувь, төсөл сангийн зээлийн зардалд 1.9 хувийг тус тус зарцуулжээ.

⁵ газрын төлбөрийн 40 хувь.

Хүснэгт 6: Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл:

мянган төгрөг

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	71,671,857.1	64,528,242.1	7,146,237.3	90.0
НИЙТ ЗАРЛАГА	68,817,886.5	63,293,087.3	5,524,799.2	92.0
УРСГАЛ ЗАРДАЛ	67,356,477.0	61,973,578.5	5,382,898.5	92.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,932,264.5	57,853,963.9	4,078,300.6	93.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,242,348.7	33,077,912.5	1,164,436.2	96.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,473,785.9	4,228,080.3	245,705.6	94.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,866,384.4	6,438,841.7	427,542.7	93.8
Хангамж, бараа материалын зардал	1,614,360.4	1,555,438.5	58,921.9	96.4
Нормативт зардал	4,015,325.0	2,926,911.2	1,088,413.8	72.9
Эд хогшил, урсгал засварын зардал	500,057.9	437,535.8	62,522.1	87.5
Томилолт, зочны зардал	210,921.4	147,332.1	63,589.3	69.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,111,679.8	1,058,392.0	53,287.8	95.2
Бараа үйлчилгээний бусад зардал	8,897,401.0	7,983,519.8	913,881.2	89.7
ТАТААС	12,000.0	2,000.0	10,000.0	16.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,412,212.5	4,117,614.6	1,294,597.9	76.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,997,675.3	2,993,700.8	1,003,974.5	74.9
Бусад урсгал шилжүүлэг	1,414,537.2	1,123,913.7	290,623.5	79.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,461,409.5	1,319,508.8	141,900.7	90.3
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,853,970.6	1,235,154.8	1,621,438.1	43.2

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Бүх шатны захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимд шилжих, зөвхөн зайлшгүй шаардлагатай зардлыг батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлэн ажилласан байна.

Харин төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан иж бүрдлийг хангаж ирүүлээгүйгээс батлагдсан орон тооны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байлаа.

Аймгийн төсвийн зарлага өмнөх оноос 3,858,098.3 мянган төгрөгөөр буюу 6.4 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 7: Зардлын ангилал

мянган төгрөг

Үзүүлэлт	2019 оны гүйцэтгэл	2020 оны гүйцэтгэл	Өөрчлөлт	Өөрчлөлтийн хувь
Нийт зарлага ба ний зээлийн дүн	60,670,143.8	64,528,242.1	3,858,098.3	6.4
Урсгал зардал	57,654,040.9	61,973,578.5	4,319,537.6	7.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	53,227,748.3	57,853,963.9	4,626,215.6	8.7
Татаас ба урсгал шилжүүлэг	4,426,292.6	4,119,614.6	(306,678.0)	(6.9)
Хөрөнгийн зардал	1,753,689.0	1,319,508.8	(434,180.2)	(24.8)
Эргэж төлөгдөх зээл	1,262,413.9	1,235,154.8	(27,259.1)	(2.2)

Эх сурвалж: Булган аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Татаас болон урсгал шилжүүлгийн зардал 6.4 хувиар, бараа ажил үйлчилгээний бусад зардал 8.7 хувиар нэмэгдэж, татаас ба урсгал шилжүүлэг 6.9 хувиар, хөрөнгийн зардал 24.8 хувиар, эргэж төлөгдөх зээл 2.2 хувиар тус тус буурчээ.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.⁶, 16 дугаар зүйлийн 16.5.3⁷, 16.5.5⁸, Засгийн газрын "Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай" 2014 оны 147 дугаар тогтоолуудын зарим заалтыг мөрдөөгүйгээс төсвийг зориулалт бусаар, үр ашиггүй, үрэлгэн зарцуулснаас алдаа зөрчил өмнөх оноос 9,154.1 мянган төгрөгөөр 63.8 хувиар өсчээ.

Аудитын илрүүлэлт:

- Хорио цээр тогтоосонтой холбоотой сургалтын үйл ажиллагааг танхимаар явуулахгүй түр хугацаагаар зогсоосон хугацаанд багш ажилчдад хоолны нэмэгдэл олгосон. *Тухайлбал: Булган сумын 1, 2, 3-р сургууль, Спортын дунд сургууль 2, 6, 7-р цэцэрлэг нийт 50.9 сая төгрөг.*
- Сумын Засаг дарга албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 2.3, 4.7 дахь заалтыг зөрчин үр дүнгийн урамшууллыг аймгийн Засаг даргын шийдвэртэй давхардуулан олгосон. *Тухайлбал: Булган сумын 3-р сургууль, Хангал сумын сургууль, цэцэрлэг, Орхон сумын цэцэрлэг 2.7 сая төгрөг.*
- Аймгийн Засаг дарга албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 2.3, 4.7 дахь заалтуудыг зөрчин зарим агентлаг, байгууллагын дарга нарт үр дүнгийн урамшуулал олгосон. *Тухайлбал: Нийгмийн даатгалын хэлтэс, Ус цаг уур орчны шинжилгээний газар, Шүүхийн шинжилгээний алба, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нийт 1.6 сая төгрөг.*
- Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийсэн. *Тухайлбал: Байгаль орчин аялал жуулчлалын газар, Бугат сумын ЗДТГ, Эмийн цэцэглэн өрхийн эмнэлэг, Хялганат сумын ЭМТ, ОНХС 3.2 сая төгрөг.*
- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 дахь "Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" гэсэн заалтыг зөрчсөн шагналын дагалдах мөнгө олгосон. *Тухайлбал: Тэшиг сумын сургууль, Хутаг-Өндөр сумын сургууль, Хишиг-Өндөр сумын соёлын төв нийт 1.5 сая төгрөг.*
- Төсөвт батлагдаагүй цалингийн зардлаас хавсран ажилласан нэмэгдэл, зориулалт бусаар зарцуулсан, цалинг зөрүүтэй тооцсон, сахилгын шийтгэлтэй албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгосон. *Тухайлбал: Баяннуур, Хутаг-Өндөр сумын сургууль, Булган сумын 3-р цэцэрлэг, Дашинчилэн, Могод, Орхон, Рашаант, Сайхан, Хишиг-Өндөр, Баяннуур, Баян-Агт сумдын цэцэрлэг, цэргийн штаб, ОНӨАлба, Цоожид өрхийн эмнэлэг, Хялганат ЗАА, Бүрээхангай, Баяннуур сумын ЗДТГ, Баяннуур, Рашаант, Сайхан сумдын ЭМТ, Нэгдсэн эмнэлэг, Бугат сумын соёлын төв, Эрүүл мэндийн газар нийт 35.1 сая төгрөг.*
- ТБОНӨХБАҮХАТухай хуулийг хэрэгжүүлэн тендер зохион байгуулаагүй, шууд гэрээгээр худалдан авалт хийсэн. *Тухайлбал: Могод, Баян-Агт, Баяннуур сумын цэцэрлэг, Бүрээхангай, Тэшиг, сумын ЭМТ нийт 165.6 сая төгрөг.*
- Тооцоолсон цалинг цалингийн өглөг дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэж, УСНББОУС мөрдөөгүй. *Тухайлбал: Бүрээхангай, Могод, Рашаант, Сайхан, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Бугат, Баян-Агт, Баяннуур, Булган сумын 6-р цэцэрлэг, Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлэг, Сэлэнгэ, Хангал, Баян-Агт, Тэшиг, Сайхан сумын ЭМТ нийт 603.9 сая төгрөг.*
- Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, тооцоо бодоогүй, дансны ангилал буруу бүртгэсэн. *Тухайлбал: Хишиг-Өндөр сумын сум дундын эмнэлэг, Хангал, Баян-Агт, Баяннуур, Дашинчилэн, Сэлэнгэ, Тэшиг,*

⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁷ батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;

⁸ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

Сайхан сумын ЭМТ, Рашаант, Хишиг-өндөр сумын сургууль, нийт 789.2 сая төгрөг.

2.1.2 Аймгийн төсвийн зарлагын гүйцэтгэл:

Аймгийн төсвийн зарлагыг 22,616,294.8 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 21,609,196.1 мянган төгрөг зарцуулж, 887,098.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулжээ. Нийт зардлын 95.8 хувийг урсгал, 4.2 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж, урсгал зардлын 63.1 хувийг бараа ажил үйлчилгээний зардалд, 34.6 хувийг татаас, урсгал шилжүүлгийн зардалд, 2.3 хувийг бусад урсгал зардалд зарцуулжээ.

Аймгийн төсвөөс сумдын төсөвт 5,553,123.7 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор батлагдаж, санхүүжилтийг бүрэн олгожээ. Өмнөх оны гүйцэтгэлээс 768,921.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.1.3 Сумдын төсвийн зарлагын гүйцэтгэл:

Сумдууд 2020 онд 49,055,562.3 мянган төгрөгийг зарцуулахаар баталснаас гүйцэтгэлээр 48,472,581.1 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 582,981.2 мянган төгрөг буюу 1.2 хувийг дутуу зарцуулжээ.

2019 оны гүйцэтгэлтэй харьцуулбал сумдын төсвийн зарлага нийт дүнгээрээ 2,213,001.6 мянган төгрөг буюу 4.8 хувиар нэмэгджээ.

БҮЛЭГ 3. ХУДАЛДАН АВСАН БАРАА АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 91.6 хувьтай гарч, өмнөх оноос 4,716.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

3.1.1 Аймагт 2020 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, авто замын сан, байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн эх үүсвэрээр нийт 11,513,289.1 мянган төгрөгийн гэрээний дүн бүхий 93 төсөл арга хэмжээнд нийт 8,405,697.1 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан байна. Үүнээс ажлын гүйцэтгэлээр нь 7,074,337.4 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагуудад олгож, 6,607.9 мянган төгрөгийн алданги, 364,994.7 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө, 234,148.9 мянган төгрөгийн магадлашгүй ажил, техник хяналтын зардлыг суутган тооцож, холбогдох дансанд төвлөрүүлж, 1,002,703.5 мянган төгрөгийг 2021 онд дамжин санхүүжүүлэхээр, 191,128.5 мянган төгрөг нь тендер шалгараагүй болон төсвийн хэмнэлт гарч орон нутгийн төсвийн дансанд үлджээ.

Гүйцэтгэлээр олгосон санхүүжилт нь 2020 онд санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын ажлын 91.6 хувь болж, өмнөх оноос 25.2 пунктээр буурсан сөрөг үзүүлэлттэй байна.

3.1.2 *Орон нутгийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл:* 5 төсөл арга хэмжээнд нийт 949,614.3 мянган төгрөгийн гэрээ байгуулагдсанаас 2020 онд аймгийн төсвийн хөрөнгөөр 3 ажилд 102,580.0 мянга, 2018-2020 он дамжин хэрэгжих 2 ажилд 535,181.5 мянга, нийт 5 ажилд 637,761.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр нийт 99.6 хувь буюу 635,340.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 0.2 хувь буюу 1,252.5 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон гэрээний хэмнэлт гарсан байна.

3.1.3 *Замын сангийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл:* 7 төсөл, арга хэмжээнд 325,500.0 мянган төгрөгийн гэрээ байгуулагдсанаас 2020 онд 325,500.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 6 төсөл арга хэмжээнд нийт 72.9 хувь буюу 237,219.7 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 27.1 хувь буюу 88,280.3 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон гэрээний хэмнэлт гарсан байна.

3.1.4 *Аймгийн ОНХС-гийн санхүүжилтийн гүйцэтгэл:* Аймгийн 2020 онд төлөвлөсөн болон өмнөх оноос он дамжсан нийт 15 төсөл арга хэмжээнд 3,115,671.7 мянган төгрөгийн гэрээ байгуулагдсанаас, 1,878,496.5 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр нийт 85.6 хувь буюу 1,609,032.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 20.3

хувь буюу 631,523.5 мянган төгрөгийг 2021 онд санхүүжүүлэхээр батлагдаж, 443.1 мянган төгрөгийн алданги, 22,198.9 мянган төгрөгийн магадлашгүй ажил, техник хяналтын зардлыг суутган тооцож, холбогдох дансанд төвлөрүүлсэн байна.

Аймагт 3,292,547.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснийг ОНХНС-аас 403,099.2 мянган төгрөгөөр дутуу хуваарилжээ. ОНХНС-аас хуваарилагдаж ирсэн санхүүжилтээс 2,150,836.7 мянган төгрөгийг аймагт, 1,141,710.3 мянган төгрөгийг сумдуудад тус тус хуваарилжээ.

3.1.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл: 27 төсөл арга хэмжээнд нийт 8,707,907.5 мянган төгрөгийн гэрээ байгуулагдаж, 2020 онд 6,663,722.5 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр нийт 91.8 хувь буюу 6,116,022.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 8.2 хувь буюу 547,700.3 мянган төгрөг нь төсөвт үлдсэн дүн болон гэрээний хэмнэлт гарсан байна.

3.1.6 Сумын ОНХС-гийн санхүүжилтийн гүйцэтгэл: 2020 онд төлөвлөсөн болон өмнөх оноос он дамжсан нийт 163 ажилд 1,315,058.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр 842,943.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, 135,759.9 мянган төгрөгийн 20 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй, 472,115.1 мянган төгрөг нь сумдуудын ОНХС-гийн дансанд үлджээ. /Хавсралт3/

БҮЛЭГ 4. ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛСАН ТӨСӨВ, ХҮРСЭН ҮР ДҮНГИЙН ТАЛААР

4.1 Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаа зөрчил арилаагүй хэвээр байна.

Төсвийн төвлөрүүлэн нар тухайн жилийн төсвийг батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6⁹-д эдийн засгийн ангиллаар, хөтөлбөрөөр, арга хэмжээгээр, санхүүжүүлэх эх үүсвэрээр, хүрэх үр дүнгийн хамт батлах заалтыг зарим сумдууд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.4¹⁰-д төсвийн захирагч нь тухайн жилийн дундуур төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнаагүй байна. Тухайлбал: Хялганат тосгон, Бүрэгхангай, Сайхан, Сэлэнгэ сумдууд хүрэх үр дүнг батлаагүй, Хялганат тосгон, Булган, Баяннуур, Бүрэгхангай, Сайхан, Орхон, Рашаант, Сэлэнгэ сумдууд, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч хүрэх үр дүнгийн биелэлтийг тооцож ажиллаагүй байна.

Өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаа зөрчил арилаагүй байна.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54.5¹¹, 54.6¹² дахь заалтыг хэрэгжүүлээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрдлийг хангаагүй, хөтөлбөрийн

⁹ Төсвийн төвлөрүүлэн захирагч нь өөрийн батлагдсан төсвийг төсвийн шууд захирагч бүрээр, энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар, хүрэх үр дүнгийн хамт батлах;

¹⁰ төсвийн захирагч нь төсвийн жилийн дундуур энэ хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн жилийн төсөвтөө өөрчлөлт оруулж, зохицуулалт хийсэн бол гүйцэтгэлийг нь анхны батлагдсан зорилт, хүрэх үр дүнтэй харьцуулж тайлагнадаг байх;

¹¹ Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна:

¹² Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу төсөвт зохицуулалт хийсэн тохиолдолд хөтөлбөрийн гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнана.

- гүйцэтгэлийг анх төлөвлөсөн хүрэх үр дүнгийн зорилттой нь харьцуулсан байдлаар тайлагнаж ирүүлдэггүй зөрчил хэвээр байна.
2. Аймгийн Засаг дарга албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлэн Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 1.2, 2.3, 4.7 дахь заалтуудыг зөрчин зарим агентлаг, байгууллагын дарга нарт үр дүнгийн урамшуулал олгосон.
 3. Орон нутгийн төсвийн орлого 5.2 хувиар тасарч, өмнөх оноос 13.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
 4. Төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийг үрэлгэн, зориулалт бус зарцуулсан зэрэг алдаа, зөрчил өмнөх оноос 63.8 хувиар өсчээ.
 5. Өмнөх онд орон нутгийн төсвийн нийт зардалд урсгал зардлын эзлэх хувийн жин 95.0 хувь байсан бол тайлант онд 96.0 хувийг эзэлж 1.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.
 6. Төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн талаар гарсан тогтоол, шийдвэр, журмын зарим заалтыг хэрэгжүүлээгүйгээс төсвийг үрэлгэн, зориулалт бус зарцуулсан зэрэг алдаа, зөрчил өмнөх оноос 63.8 хувиар өссөн байна.
 7. Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 91.6 хувьтай гарч, өмнөх оноос 4,716.0 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.
 8. Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх, хөтөлбөр, хүрэх үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтэд дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаа зөрчил арилаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИД:

1. Жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан иж бүрдлийг хангаж ирүүлж байх,
2. Аймаг, сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэх, Цагдаагийн байгууллагад бүртгэлтэй галт зэвсэг, АТҮТ-ын Булган салбарт бүртгэлтэй автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн зөрүүг арилгах ажлыг орлого төвлөрүүлдэг байгууллагатай хамтран зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнах,
3. Сумдын төсвийн төвлөрүүлэн захирагч нараас төсөвтэй холбоотой хууль, тогтоомж, журам, зааврыг мөрдөх, төсвийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулж байгаа зөрчлийг таслан зогсоох,
4. Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 2.1-д заасан аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба чиг үүргээ хэрэгжүүлж, батлагдсан хөтөлбөр арга хэмжээ, төсвийн орлого, зарлагын хэрэгжилтэд тавих хяналтыг нэмэгдүүлэн, дүн шинжилгээ хийж байх.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР